



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

“Улаанбаатар чуулга” ОНӨААТҮГ-ын балансаас хөрөнгө шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 1,051,600 /нэг сая тавин нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Соёл урлагийн газрын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг “Улаанбаатар чуулга” ОНӨААТҮГ /Р.Мөнхсайхан/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн Соёл урлагийн газар /Ж.Дамдинцэрэн/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Улаанбаатар чуулга” ОНӨААТҮГ /Р.Мөнхсайхан/-т, Нийслэлийн Соёл урлагийн газар /Ж.Дамдинцэрэн/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.ОДНАСАН



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2019 оны 08 сарын 18 өдрийн
 А/30 тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Улаанбаатар чуулга ОНӨААТҮГ-аас Нийслэлийн Соёл урлагийн газарт

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ			Хөрөнгө хүлээн авах байгууллага		
						Нэгж үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн элэгдэл		Үлдэх хөрөнгө	
1	Ажлын ширээ		2015	ш	4	262,900.00	1,051,600.00	832,516.66	219,083.34	Нийслэлийн Соёл урлагийн газар	
Тавилга, эд хогшлын дүн											
Нийт							1,051,600.00	832,516.66	219,083.34	219,083.34	